



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/154

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3./а/, 29.2, Монгол Улсын Их хурлын 2009 оны 23-р тогтоол, Үндсэн чиглэл батлах тухай 2016 оны II тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны Ээлжит Ү хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид, мал бүхий өрхөд төр засгийн болон орон нутгийн бодлого, шийдвэрийг хүргэх, нийгмийн зарим үйлчилгээ үзүүлэх, мал онд оруулах, төл бойжуулах ажлыг зохион байгуулах, цагийн байдалд үнэлгээ өгч, хяналт тавих, зэргэлдээ аймаг, сумдуудтай хамтран ажиллахад шаардагдах шатахууны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөө ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, явах чиглэлийг батлуулж, ажлын хэсгийг нэгдсэн удирдамжаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч дүн мэдээг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т үүрэг болгосугай.

3. Хөдөө ажиллах шатахууны зардалд шаардагдах 4898000 /дөрвөн сая найман зуун ерөн найман мянга/ төгрөгийг хуваарилагдаагүй бусад /Малын өвөлжилт, хаваржилтыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

02000 0779

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын
 30-ны өдрийн 4/154 дугаар захирамжийн хавсралт



ХӨДӨӨД АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Явах газрын чиглэлийн нэр	Нэг удаа явах км	Нийт явах тоо	Бүгд явах /км/	100км-т зарцуулах шатахуун /л/	Нийт шатахууны хэмжээ /л/	1 литр шатахууны үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Баянцагаан, 4 подъём	250	4	1000	20	200	1580	316000
2	Зүйл, Тариа бригад	350	4	1400	20	280	1580	442400
3	Ханхар	450	4	1800	20	360	1580	568800
4	Хонгор овоо	350	4	1400	20	280	1580	442400
5	Залуугийн өвөр, Бухын даваа	350	4	1400	20	280	1580	442400
6	Баян-Өндөр сумын төвийн багууд	200	4	800	20	160	1580	252800
7	Нарангаас-Шувуут	350	4	1400	20	280	1580	442400
8	Дулааны энгэр, Хөшөөт, Ихэрийн бууц	360	4	1440	20	280	1580	442400
9	136 точек, Согоот, Хутагын шанаа	350	4	1400	20	280	1580	442400
10	Цагаан хуст, Арцатын даваа	300	4	1200	20	240	1580	379200
11	Жаргалант сумын төвийн багууд	200	4	800	20	160	1580	252800
	Хил залгаа аймаг, сумуудтай хамтран ажиллах	500	3	1500	20	300	1580	474000
	Нийт дүн	4010	4	16040	20	3100	1580	4898000